



ШИНЖЛЭХ УХААҢ, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/113

Улаанбаатар хот

ШУТИС-ийн багш, ажилтны ажлын
гүйцэтгэлийг үнэлж, урамшуулах журам
батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 5 тоот тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам", ШУТИС-ийн дүрмийн 4.9.2, 4.14.7, 10.2 дахь заалтууд, ШУТИС-ийн 2018 оны Хамтын гэрээний 2.10 дахь заалт, 2019 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Эвлэрүүлэн зуучлах хурлын протокол, Захирлын зөвлөлийн 2019 оны 3 дугаар сарын 19, 5 дугаар сарын 07-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. ШУТИС-ийн "Багш, ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлж, урамшуулах журам"-ыг хавсралтаар баталж, 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.
2. Батлагдсан журмыг хэрэгжүүлэн, хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ эрхэлсэн дэд захирал (Ц.Баатархүү), Захиргаа, хүний нөөцийн газрын дарга (Н.Ганзориг), бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн захирал, дарга нарт үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Б.ОЧИРБАТ



ШУТИС-ийн Захирлын 2019 оны 05 сарын
02 өдрийн Ажлаас тоот тушаалын хавсралт

	ШУТИС-ийн БАГШ, АЖИЛТНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЖ, УРАМШУУЛАХ ЖУРАМ MUST-HR-P02	Эхний хэвлэлт	2011/01/14
		Өөрчилсөн огноо	2019/03/19
		Өөрчлөлтийн дугаар	1

ШУТИС-ийн БАГШ, АЖИЛТНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЖ, УРАМШУУЛАХ ЖУРАМ

Боловсруулсан:

1. ЗАХИРГАА, ХҮНИЙ НӨӨЦИЙН ГАЗАР
2. ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗАР
3. ЧАНАРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЛБА

Дэмжсэн:

1. ШУТИС-ИЙН ЗАХИРЛЫН ЗӨВЛӨЛ

Баталсан:


1. ШУТИС-ИЙН ЗАХИРАЛ

Энэ баримт бичиг нь тусгайлан өөрөөр заагаагүй бол ШУТИС-ийн өмч бөгөөд бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр энэ баримтыг бүрэн эхээр нь буюу хэсэгчлэн хуулбарлах, хадгалах, дамжуулах, шилжүүлэх, баримтын агуулга болон дизайныг өөр баримтад ашиглахыг хориглоно.



АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	3
ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ	3
ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ	3
ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ	3
ТАВ. ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЖ, УРАМШУУЛАЛ ОЛГОХ	3
Хавсралт 1. ҮЙЛ ЯВЦЫН ЗУРАГЛАЛ	10
Хавсралт 2. ХОЛБОГДОХ МАЯГТ	12



НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 ШУТИС-ийн эрхэм зорилго, алсын хараа, хөгжлийн зорилтууд, түүнд хүрэхэд чиглэсэн ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийг бодит үр дүнтэй харьцуулан, шалгуур үзүүлэлтийн тусламжтай үнэлж дүгнэн, ажлын үр дүнд тохирсон урамшуулал олгохтой холбогдох харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.2 Гүйцэтгэлийг үнэлэх, урамшуулал олгох үйл ажиллагаа нь үнэн зөв, шударга, бусдаас хамааралгүй, бодит гүйцэтгэсэн ажлыг нь тоо, чанарын хувьд нарийн ялгаж үнэлэх, мөн ил тод, үр дүнтэй байхад чиглэгдэнэ.
- 1.3 Их сургуулийн захиргааны холбогдох нэгжүүд нь жил бүрийн цалин урамшууллын бодлогын хэрэгжилтэд судалгаа хийж, удирдлагыг мэдээллээр хангах, үндсэн цалингийн болон үр дүнгийн урамшууллын үр нөлөөг дээшлүүлэхэд мэргэжлийн удирдлагаар хангах үүрэг хүлээнэ.
- 1.4 Багш, ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэх үйл ажиллагааг ШУТИС-ийн захиргаанаас удирдлагаар хангаж, явцын хяналт тавьж ажиллана.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1 ШУТИС-ийн захирлын тушаалаар батлагдсан үндсэн орон тоонд ажилладаг профессор багш, ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг урамшуулахад энэхүү журмыг мөрдөнө.
- 2.2 ШУТИС-ийн бүтцэд байгаа боловч улсын төсвийн санхүүжилтээр цалин, урамшууллын зардал нь батлагдан олгогддог нэгжүүд энэ журмын үйлчлэлд хамаарахгүй.

ГУРАВ. НОРМАТИВ ЭШ ТАТАЛТ


- 3.1 Дараах баримт бичгийг хэсэгчлэн, норматив байдлаар эш татсан болно. Үүнд:
 - Төрийн албаны тухай хууль, 2017;
 - Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам. 2012;
 - Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам, 2019;
 - “Судалгаанд суурилсан их сургууль” Үндэсний хөтөлбөр. 2018 он;
 - ШУТИС-ийн дүрэм, журмууд.

ДӨРӨВ. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

- 4.1 Гүйцэтгэлийн үнэлгээ: Их сургуулийн багш, ажилтан бүр үүрэгт ажлаа хэрхэн биелүүлж, ямар үр дүнд хүрч байгаа, мэргэшлийн бэлтгэл, ажлын ачаалал ямар байгаа талаарх мэдээлэл цуглуулж, дүгнэх үйл явц.
- 4.2 Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт: Аливаа бодлого, зорилт, төлөвлөгөө үндсэн зорилгод хэрхэн хүрч байгааг тодорхойлох хэмжүүр бөгөөд төлөвлөсөн зорилтод хүрсэн эсэхийг тодорхойлохын тулд юуг хэмжиж, үнэлэхийг гаргаж өгнө.
- 4.3 Урамшуулал: Байгууллагын ажлын эцсийн үр дүнд багш, ажилтны оруулсан хувь нэмэр, хүчин чармайлтыг үнэлэн, ажил олгогчоос олгож буй мөнгөн урамшуулал.

ТАВ. ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЖ, УРАМШУУЛАЛ ОЛГОХ

- 5.1 Ажлын гүйцэтгэлийн үнэлгээг дараах зорилгоор хийнэ. Үүнд:
 - 5.1.1 Ажил үүргээ ямар түвшинд гүйцэтгэж байгаа талаар удирдлага, ажилтнууд бодитой мэдээлэлтэй болох;
 - 5.1.2 Ажилтны үндсэн ажлаасаа (албан тушаалын тодорхойлолтонд зааснаас) илүү гүйцэтгэж буй ажлын хэмжээг тодорхойлох;
 - 5.1.3 Ажилтнуудын бүтээмжийг нэмэгдүүлэх сэдлийг үүсгэх;
 - 5.1.4 Сургалт, хөгжүүлэлтийн хэрэгцээ, шаардлага боломжийг тодорхойлох;



5.1.5 Цалин хөлс болон урамшуулал олгох бодит үндэслэлийг тогтоох;


5.1.6 Хангалтгүй гүйцэтгэлийг сайжруулах зэрэг болно.

5.2 Багш ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг албан тушаалын ангилалд харгалзуулан тодорхойлно. Үүнд:

5.2.1 Багшийн хувьд (ПБ ангилал, ТК, АС ангиллын багш нар):

№	Түлхүүр үзүүлэлт	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Дүгнэх оноо
1	Төлөвлөгөөт ажил (50%)	Албан тушаалын тодорхойлолт болон хөдөлмөрийн гэрээнд заагдсан ажил үүргийг гүйцэтгэсэн байдал	50 хүртэл
2	Тусгай ажил (30%)	Сургалтын үйл ажиллагаанд дэвшилтэт арга зүй, технологи нэвтрүүлсэн, ашигласан, нутагшуулсан байдал, сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн санаачлага, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд оролцсон байдал	8
3		Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн чиглэлээр их сургуульд оруулсан хувь нэмэр	8
4		Их сургуулийн хөгжилд оруулсан материаллаг болон мөнгөн хөрөнгө оруулалт	5
5		Олон улсын, үндэсний болон их сургуулийн хэмжээнд гаргасан томоохон амжилт - Уралдаан, тэмцээн, наадам, үзэсгэлэнд оролцон байр эзэлсэн, бүтээл нь шалгарсан; - Нэрэмжит тэтгэлэг, грант хүртсэн; - ШУТИС-ийн шилдэг багшийн шалгаруулалтанд байр эзэлсэн;	5
6		Олон улсын түвшинд их сургуулийг төлөөлөн ажилласан байдал (шинжээч, зөвлөх, зочин професороор ажиллах г.м)	4
7		Багшлах ур чадвар, мэргэжил, хувь хүний хөгжлөө дээшлүүлсэн байдал: - Гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан; - Зөвлөх, мэргэшсэн инженерийн сургалтанд хамрагдсан; - Эрдмийн зэрэг хамгаалсан, Эрдмийн цол хүртсэн	5
8	Онцгой үүрэг, даалгавар биелүүлсэн байдал (Их сургуулийн тавьсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр удирдлагаас тусгайлан даалгасан үүрэг даалгаврыг хэрэгжүүлсэн байдал)	5*	
9	Удирдлагаас өгсөн, хугацаатай үүрэг даалгаврын биелэлт, шууд удирдлагын үнэлгээ	5	
10	Хамтран ажилладаг хамт олны (газар, алба, салбар, тэнхим) үнэлгээ	5	
		Оюутан, суралцагчийн зүгээс багшлах үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ	5
		Нийлбэр оноо	100

*- энэ үнэлгээг тооцох тохиолдолд "Хувь хүний чадамж-20%" хэсэгт хамаарах бусад шалгуур үзүүлэлтийг багасгаж, нийт оноог 20-с хэтрүүлэхгүйгээр тооцно.



5.2.2 Захиргааны ажилтны хувьд (ЗА ангилал, мөн ТК, АС ангиллын харгалзах ажилтан):

№	Түлхүүр үзүүлэлт	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Дүгнэх оноо
1	Төлөвлөгөөт ажил (50%)	Албан тушаалын тодорхойлолт болон хөдөлмөрийн гэрээнд заагдсан ажил үүргийг гүйцэтгэсэн байдал	50 хүртэл
2	Тусгай ажил** (30%)	Сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, инноваци, санхүүгийн чиглэлээр их сургуульд оруулсан хувь нэмэр. Үүнд:	
		- Сургалтын үйл ажиллагаанд дэвшилтэт арга зүй, технологи нэвтрүүлсэн, ашигласан, нутагшуулахад чиглэсэн үйл ажиллагаа;	5
		- Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн ажлыг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа;	5
		- Их сургуулийн санхүүгийн чадавхийг бэхжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, үр ашгийг дээшлүүлэх, үйл ажиллагааг оновчтой болгоход чиглэсэн үйл ажиллагаа.	5
3		ШУТИС-ийн бодлогын баримт бичиг, журам, дүрэм, бусад эрх зүйн актуудыг боловсруулахад оролцсон байдал	5
4		Их сургуулийн хөгжилд оруулсан материаллаг болон мөнгөн хөрөнгө оруулалт	5
5		Олон улсын, үндэсний болон их сургуулийн хэмжээнд гаргасан томоохон амжилт - Уралдаан, тэмцээн, наадам, үзэсгэлэнд оролцон байр эзэлсэн, бүтээл нь шалгарсан; - Нэрэмжит тэтгэлэг, грант хүртсэн;	5
6		Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны норм, дүрэм, үйл ажиллагааны стандартыг баримтлан ажилласан байдал	5
7		Эд хөрөнгийн болон санхүүгийн хариуцлага алдахгүй ажилласан байдал	5
8		Албан бичиг хэрэг хөтлөлт, архивт хүлээлгэн өгсөн байдал	5
9		Тайлан, мэдээ мэдээллийг хугацаанд нь гаргасан байдал	5
10		Онцгой үүрэг, даалгавар биелүүлсэн байдал (Их сургуулийн тавьсан зорилго, зорилт, удирдлагаас хэрэгжүүлэх үйл ажиллагааг хангах чиглэлээр удирдлагаас тусгайлан даалгасан үүрэг даалгаврыг хэрэгжүүлсэн байдал)	5
11	Хувь хүний чадамж** (20%)	Мэргэжил, ур чадвар, хувь хүний хөгжлөө дээшлүүлсэн байдал: - Гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан; - Эрдмийн зэрэг хамгаалсан, эрдмийн цол хүртсэн.	5
12		Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлсэн байдал, шууд удирдлагын үнэлгээ	5
13		Иргэн, багш, оюутан, суралцагчаас ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг бүрэн шийдвэрлэсэн, түүний дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	5
14		Ажлын байрны цаг ашиглалтын байдал	5
15		Хамтран ажилладаг хамт олны (газар, алба, салбар, тэнхим) үнэлгээ	5
		Нийлбэр оноо	100



** - тухайн албан тушаалын ангиллаас хамааран, түлхүүр үзүүлэлтийн ноогдох хувьд харгалзах гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг сонгон үнэлнэ.


"Тусгай ажил (30%)" = харгалзах шалгуур үзүүлэлтүүдийн нийлбэр 30 оноо,
 "Хувь хүний чадамж (20%)" = харгалзах шалгуур үзүүлэлтүүдийн нийлбэр 30 оноо

5.2.3 Ажилтны хувьд (ГА ангилал, мөн ТК, АС ангиллын харгалзах ажилтан):

№	Түлхүүр үзүүлэлт	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Дүгнэх оноо
1	Төлөвлөгөөт ажил (50%)	Албан тушаалын тодорхойлолт болон хөдөлмөрийн гэрээнд заагдсан ажил үүргийг гүйцэтгэсэн байдал	50 хүртэл
2	Тусгай ажил*** (30%)	Байгууллагын үйл ажиллагаанд шинэ арга, техник, технологи, нэвтрүүлэх, ашиглахад хувь нэмэр оруулсан байдал	5
3		Их сургуулийн хөгжилд оруулсан материаллаг болон мөнгөн хөрөнгө оруулалт	5
4		Олон улсын, үндэсний болон их сургуулийн хэмжээнд гаргасан томоохон амжилт - Уралдаан, тэмцээн, наадам, үзэсгэлэнд оролцон байр эзэлсэн, бүтээл нь шалгарсан; - Нэрэмжит тэтгэлэг, грант хүртсэн;	5
5		Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны норм, дүрэм, үйл ажиллагааны стандартыг баримтлан ажилласан байдал	5
6		Хөдөлмөрийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах, бүтээмжийг дээшлүүлэн ажилласан байдал	5
7		Барилга байгууламжийн инженерийн шугам сүлжээг доголдолгүй ажиллуулсан, техник үйлчилгээ, цэвэрлэгээг бүрэн хийсэн байдал	5
8		Тайлан, мэдээ мэдээллийг хугацаанд нь гаргасан байдал	5
9		Албан бичиг хэрэг хөтлөлт, архивт материал хүлээлгэн өгсөн байдал	5
10		Эд хөрөнгийн болон санхүүгийн хариуцлага алдахгүй ажилласан байдал	5
11		Хувь хүний чадамж (20%)	Мэргэжил, ур чадвар, хувь хүний хөгжлөө дээшлүүлсэн байдал
12	Ажлын байрны цаг ашиглалтын байдал		5
13	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлсэн байдал, шууд удирдлагын үнэлгээ		5
14	Хамтран ажилладаг хамт олны (газар, алба, салбар, тэнхим) үнэлгээ		5
		Нийлбэр оноо	100

*** - тухайн албан тушаалын ангиллаас хамааран, түлхүүр үзүүлэлтийн ноогдох хувьд (30%) харгалзах гүйцэтгэлийн 6 шалгуур үзүүлэлтүүдийг (6 үзүүлэлт х 5 оноо=30 оноо) сонгон үнэлнэ.

- 5.3 Ажлын гүйцэтгэлийн үнэлгээ 71 хувь буюу түүнээс дээш үед урамшуулал олгох бөгөөд ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг ШУТИС-ийн захиргаа, бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, нэгжүүд хамтран зохион байгуулна.
- 5.4 Гүйцэтгэх ажилтанд тухайн албан тушаалын 1 сарын үндсэн цалингийн 10 хүртэлх хувиар тооцон сар бүр, профессор багш, захиргааны ажилтанд тухайн албан тушаалын 1 сарын үндсэн цалингийн 50 хүртэлх хувиар тооцон хичээлийн жилийн улирал бүр урамшуулал олгоно.



5.5 Ажлын гүйцэтгэлийн үр дүнг дараах үнэлгээний шатлалаар хэмжинэ.

№	Нийт үнэлгээний оноо	Тайлбар	Харгалзах урамшууллын хувь хэмжээ
1	91-100	Дээд үнэлгээ буюу багш, ажилтны гүйцэтгэлийн өндөр үзүүлэлт.	тухайн сар буюу улиралд олгох урамшууллыг 100 хувь олгоно. (сард: ГА-1 сарын цалингийн 10%, улиралд: ПБ, ЗА- 1 сарын цалингийн 50%)
2	81-90	Хангалттай сайн үнэлгээ буюу багш, ажилтны ажиллах үр чадвар, идэвх санаачлага, гүйцэтгэлийн түвшин өндөртэйг илэрхийлнэ.	тухайн сар буюу улиралд олгох урамшууллын 75 хувийг олгоно. (сард: ГА-1 сарын цалингийн 7,5%, улиралд: ПБ, ЗА -1 сарын цалингийн 37,5%)
3	71-80	Сайн үнэлгээ буюу гүйцэтгэлийн хүлээн зөвшөөрөхүйц түвшинд хүрснийг илэрхийлнэ.	тухайн сар буюу улиралд олгох урамшууллын 50 хувийг олгоно. (сард: ГА-1 сарын цалингийн 5%, улиралд: ПБ, ЗА -1 сарын цалингийн 25%)
4	51-70	Гүйцэтгэлийн дундаж үнэлгээ буюу багш, ажилтан идэвх санаачлага гарган ажиллаж буйг илтгэнэ.	-
5	50	Багш, ажилтан зөвхөн албан тушаалын тодорхойлолтод заагдсан, төлөвлөгөөт ажил үүргийг бүрэн гүйцэтгэсэнг илтгэх үнэлгээ	-
6	0-49	Багш, ажилтан нь албан тушаалын тодорхойлолтод заагдсан ажил үүргийг бүрэн гүйцэтгэхгүй байгааг илтгэх үнэлгээ	-

Жич: албан тушаалын тодорхойлолтод заагдсан ажил үүргийг (төлөвлөгөөт ажил) хангалтгүй гүйцэтгэж байгаа тохиолдолд ажилтны ажлын гүйцэтгэлийг сайжруулах талаар холбогдох арга хэмжээг тухайн нэгжийн удирдлагаас авах үүрэгтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд Хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн гэрээг үндэслэн хариуцлага тооцох саналыг гаргана.

- 5.6 Сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн чиглэлд гүйцэтгэсэн зарим ажилд олгох урамшууллыг тусгайлан тооцно. Тусгайлсан урамшуулал олгох ажлыг дүгнэх аргачлал, харгалзах урамшууллын хэлбэр, хувь хэмжээ, мэргэжлийн комиссын ажиллах удирдамжийг ШУТИС-ийн Захирлын тушаалаар батлан мөрдөнө.
- 5.7 Сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн ажлын үр дүнгээр олгох тусгайлсан урамшууллыг хичээлийн жилд 1 удаа олгоно.
- 5.8 Сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн ажлын үр дүнгээр тусгайлсан урамшууллыг дараах ажлуудад олгоно. Үүнд:
- Web of Science, Scopus зэрэг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн индекстэй, чансаа өндөртэй сэтгүүлд ШУТИС-ийн нэр дээр эрдэм шинжилгээний бүтээл, өгүүлэл хэвлүүлсэн;
 - Судалгааны ажлын үр дүнгээр олон улсын, үндэсний хэмжээний томоохон шагнал хүртсэн;
 - Улсын болон ШУТИС-ийн төсвийн бус хөрөнгө, эх үүсвэрээр иж бүрдэл тоног төхөөрөмж бүхий судалгааны лаборатори байгуулсан;

- Судалгааны лаборатори магадлан итгэмжлүүлсэн;
- Инновацийн шинэ бүтээгдэхүүн, технологи гарган үйлдвэрлэлд нэвтрүүлсэн;
- Сургалтын хөтөлбөрийг олон улсад магадлан итгэмжлүүлсэн.


Жич: Тусгайлсан урамшуулал олгосон тохиолдолд 5.3-р заалтад тусгагдсан гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтэнд эдгээр ажлуудыг хамааруулан тооцохгүй.

5.9 Их сургуулийн удирдлагын мэдээллийн системийн өөрийн үнэлгээний дэд системд багш, ажилтны оруулсан ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийн мэдээллийг хянан, баталгаажуулах үйл явцыг бүтцийн нэгжүүд хариуцан зохион байгуулна.

5.10 Гүйцэтгэлийг үнэлэх, үнэлүүлэхдээ доор дурьдсан албан тушаалтнуудын хуваарилалтыг баримтална.

№	Бүлэг	Гүйцэтгэлийг үнэлэх удирдах албан тушаал	Гүйцэтгэлээ үнэлүүлэх албан тушаал
1	ШУТИС-ийн Захиргаа	ШУТИС-ийн захирал	<ul style="list-style-type: none"> • ШУТИС-ийн дэд захирал • Бүрэлдэхүүн сургуулийн захирал • ШУТИС-ийн захиралд шууд харьяалагдах газрын дарга, төвийн захирал,
2		ШУТИС-ийн дэд захирал	<ul style="list-style-type: none"> • Харьяалагдах газар, алба, нэгжийн дарга • ШУТИС-ийн захирал • Хүрээлэн, ШУТИС-ийн дэд захиралд шууд харьяалагдах төвийн захирал
3		Газар, албаны дарга, ШУТИС-ийн захирал	<ul style="list-style-type: none"> • Ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн • Ажилтан • Бүрэлдэхүүн сургуулийн дэд захирал (30%) • Бүрэлдэхүүн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга (30%) • Бүрэлдэхүүн сургуулийн ахлах нягтлан бодогч (30%) • Нягтлан бодогч • Бусад /
4	Бүрэлдэхүүн сургууль (коллеж, ахлах сургууль)	Бүрэлдэхүүн сургуулийн захирал	<ul style="list-style-type: none"> • Бүрэлдэхүүн сургуулийн дэд захирал (70%) • Бүрэлдэхүүн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга (70%) • Бүрэлдэхүүн сургуулийн ахлах нягтлан бодогч (70%), тооцооны нягтлан бодогч • Сургалтын албаны дарга • Салбар, тэнхимийн эрхлэгч • Харьяалах төвийн захирал, эрхлэгч • Менежер • Үйлчилгээний ажилтнууд
5		Бүрэлдэхүүн сургуулийн дэд захирал	<ul style="list-style-type: none"> • Ажилтан
6		Эрдэмтэн нарийн бичгийн дарга	<ul style="list-style-type: none"> • Ажилтан
7		Салбар, тэнхимийн эрхлэгч	<ul style="list-style-type: none"> • Салбар, тэнхимийн профессор багш • Ажилтан • Бусад
8	Хүрээлэн, төв	Хүрээлэн, төвийн захирал	<ul style="list-style-type: none"> • Мэргэжилтэн • Ажилтан • Нягтлан бодогч • Бусад

5.11 Багш, ажилтны ажлыг дүгнэж, урамшуулал олгох асуудлыг хэлэлцсэн протокол, шийдвэрийг албан ёсоор үйлдэж, нэгж, салбар, тэнхимд хадгална.




- 5.12 Ажлын үр дүнгийн гүйцэтгэлийн үнэлгээний мэдээллийг удирдах албан тушаалтнууд тухай бүр багш, ажилтнуудад хүргэж байна.
- 5.13 Ажлын гүйцэтгэлийн болон сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн тусгайлсан урамшууллыг дараах багш, ажилтанд олгохгүй. Үүнд:
 - 5.13.1 Сахилгын шийтгэлтэй байх хугацаанд;
 - 5.13.2 Ажил олгогчийн санаачлагаар хөдөлмөрийн гэрээ нь цуцлагдсан (Хөдөлмөрийн тухай хуулийн 40.1.3, 40.1.6 заалтууд хамаарахгүй);
 - 5.13.3 Туршилтын хугацаанд ажиллаж байгаа;
 - 5.13.4 ШУТИС-тай хөдөлмөрийн гэрээнээс бусад гэрээ байгуулан түр ажиллаж буй иргэн;
 - 5.13.5 Багш, захиргааны ажилтны хувьд тухайн хичээлийн жилийн улирлын, гүйцэтгэх ажилтны хувьд тухайн сарын нийт үргэлжлэх хугацааны 50 хувиас дээш хугацаанд хүндэтгэх шалтгааны улмаас ажиллаагүй, албан ёсны чөлөөтэй байсан, түр чөлөөлөгдсөн.
- 5.14 Тухайн хичээлийн жилд чөлөөлөгдсөн багш, ажилтанд урамшуулал олгохдоо ажилласан хугацаанд харгалзуулан тооцно.
- 5.15 Урамшуулал олгохдоо тухайн оны төсөвт тусгагдан батлагдсан зардлын хэмжээг баримтална.
- 5.16 Албан тушаалын тодорхойлолтонд заагдсан, төлөвлөгөөт ажил үүргээ хангалттай гүйцэтгэсэн боловч ажлын гүйцэтгэлийн урамшуулал авах нөхцлийг хангаагүй нь тухайн багш, ажилтан ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн гэж үзэх үндэслэл болохгүй.
- 5.17 Ажлын гүйцэтгэлийн үнэлгээтэй холбогдон гарсан маргаан, гомдлыг холбогдох дүрэм, журмын хүрээнд шийдвэрлэнэ.


Хавсралт 1. ҮЙЛ ЯВЦЫН ЗУРАГЛАЛ

1. ШУТИС-ийн багш, ажилтны гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг гарган үнэлэх, баталгаажуулах үйл явцыг дараах схемийг баримтлан зохион байгуулна.

1. ШУТИС-ийн багш, ажилтнуудын ажлын гүйцэтгэлийг үнэлж, урамшуулах үйл явц			
Оролт: Ажлын гүйцэтгэлийн үнэлгээ хийх төлөвлөгөө			
Гарлт: Багш, ажилтны гүйцэтгэлийн үнэлгээ			
Оролт	Үйл явц	Гарлт	Хариуцах эзэн
1.1 Ажлын гүйцэтгэлийн үнэлгээ хийх төлөвлөгөө		Ажлын гүйцэтгэлийн үнэлгээ хийх удирдамж, хуваарь, маягтууд	<ul style="list-style-type: none"> Захиргаа БС, хүрээлэн, төв
1.2 <ul style="list-style-type: none"> Ажлын гүйцэтгэлийн үнэлгээ хийх удирдамж, хуваарь, маягтууд Өмнөх гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт, үр дүн Тухай хичээлийн жилийн зорилго, зорилтууд 		Гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт бүхий хүснэгт	<ul style="list-style-type: none"> Гүйцэтгэлийг үнэлэх ажилтан Гүйцэтгэлээ үнэлүүлэх ажилтан
1.3 Гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт бүхий хүснэгт		Батлагдсан гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт	<ul style="list-style-type: none"> ШУТИС-ийн дэд захирал, БС-ийн захирал
1.4 <ul style="list-style-type: none"> Ажлын тайлан Ур чадварын үнэлгээ Бусад ажлын үр дүнгүүд 		Багш, ажилтны гүйцэтгэлийн өөрийн болоод удирдлагын үнэлгээ	<ul style="list-style-type: none"> Гүйцэтгэлийг үнэлэх ажилтан Гүйцэтгэлээ үнэлүүлэх ажилтан
1.5 Багш, ажилтны гүйцэтгэлийн үнэлгээ		Хянагдсан гүйцэтгэлийн үнэлгээ	<ul style="list-style-type: none"> ШУТИС-ийн дэд захирал ЗХНГ ЧХШУА БС, Хүрээлэн, төвийн захирал
1.6 Хянагдсан гүйцэтгэлийн үнэлгээ		<ul style="list-style-type: none"> Гүйцэтгэлийн үнэлгээний нэгдсэн бүртгэл Урамшуулал олгох ажилтны нэрс 	<ul style="list-style-type: none"> ЗХНГ БС, Хүрээлэн, төвийн захирал
1.7 Урамшуулал олгох ажилтны нэрс		Гүйцэтгэлийн үр дүнгийн урамшуулал	<ul style="list-style-type: none"> ЗХНГ СНББА БС, Хүрээлэн, төвийн захирал
1.8 Батлагдсан гүйцэтгэлийн үнэлгээ		Гүйцэтгэлийн үнэлгээний танилцуулга	<ul style="list-style-type: none"> ЗХНГ БС, Хүрээлэн, төвийн захирал



2. ШУТИС-ийн багш, ажилтны сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн ажлын үр дүнг тусгайлан урамшуулах үйл явцыг дараах схемийг баримтлан зохион байгуулна.



Хавсралт 2. ХОЛБОГДОХ МАЯГТ

№	Маягтын нэр	Маягтын дугаар	Хариуцах нэгж/ хадгалалт
1	Гүйцэтгэлийн үнэлгээний хүснэгт	HR-P02-F001	ЭХНГ, БС, хүрээлэн, төв
2	Сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн ажлын тусгайлсан урамшууллын бүртгэл	HR- P02-F002	ЭШИГ, СБЗГ
3	Нэгдсэн үнэлгээний бүртгэл	HR- P02-F003	ЭХНГ, БС, Хүрээлэн, төв

Маягт HR-P02-F001

Багш, ажилтны гүйцэтгэлийн үнэлгээний хүснэгт

Ажилтны нэр:
Албан тушаал:

Шууд удирдлага:
Үнэлгээний хамрах огноо:
Үнэлгээ хийсэн огноо:

№	Үнэлгээний бүлэг (түлхүүр үзүүлэлт)	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	харгалзах огноо	Үзүүлэлт тус бүрийн биелэлтийн огноо		Нийт бодит гүйцэтгэлийн огноо
				Өөрийн үнэлгээ	Удирдлагын үнэлгээ	
1						

Нийт үнэлгээ: _____

Үнэлгээ хийлгэсэн ажилтны гарын үсэг: ()

Үнэлгээг баталгаажуулсан ажилтны гарын үсэг: ()

Онцлох үр дүнгүүд (тайлант хугацаанд гаргасан гол үр дүн, амжилт): _____

Маягт HR-P02-F002

Сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн ажлын тусгайлсан урамшууллын бүртгэл

№	Харъяалал	А.Код	Албан тушаал	Ажилтны нэр	Ажлын нэр	Ажлын товч агуулга	Ажлын огноо	Олгогдсон урамшууллын хэмжээ

Маягт HR-P02-F003

Гүйцэтгэлийн үнэлгээний нэгдсэн бүртгэл

№	Харъяалал	А.Код	Албан тушаал	Ажилтны нэр	Гүйцэтгэлийн үнэлгээ	Огноо